



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

БУЛГАН АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН
СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН
ЗАХИРАЛ Д.БАТТУЯА ТАНАА

2024.03.01 № 209
танай _____ ны № _____ т

Дүгнэлт өгөхөөс татгалзсан

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган аймгийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийхээр төлөвлөсөн.

Булган аймгийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөхөөс татгалзаж байна. Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн ба өргөн тархсан гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд дүгнэлт өгөх хангалттай, зохистой аудитын нотолгоо олж авах боломжгүй байна.

Дүгнэлт өгөхөөс татгалзсан үндэслэл

1. Санхүүгийн тайланг хуулийн цаглаварт хугацаанд ирүүлээгүй,
2. Бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай гэрээ хийгээгүй, тооцоо нийлсэн акт байхгүй,
3. Бараа материалын нярвын тайлан бараа материалын тодруулга тайлангаас орлого 695.0 мянган төгрөг, зарлага 1,553.8 мянган төгрөгөөр илүү, үлдэгдэл 95.0 мянган төгрөгөөр дутуу,
4. Захирлын 2023 оны 12 дугаар сарын 08-ны А/89 дүгээр тушаалаар тооллогын комиссыг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилсон бөгөөд тооллогын комиссын ажлын тайланд 2,893,007.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 332,369.0 мянган төгрөгийн бараа материалыг тус тус тоолсон гэж тусгасан нь санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн тодруулга тайлангаас 596,750.3 мянган төгрөгөөр дутуу, бараа материалын тодруулга тайлангаас 4,995.8 мянган төгрөгөөр илүү тайлагнасан,
5. Тооллогын тооцоо бодсон баримтад тооллогын комиссын гишүүд бүрэн баталгаажуулаагүй
6. Үйл ажиллагааны орлого 4,580.0 мянган төгрөгийг бүрдүүлж улсын төсөвт төвлөрүүлсэн ч 260.0 мянган төгрөгийн орлогын анхан шатны баримтгүй,
7. МСҮТ-ийн захирлын 2016 оны А/56 дугаар тушаалаар батлуулсан "МСҮТ-ийн

006020488

- танхимын болон үйлдвэрлэлийн дадлага ажлыг зохион байгуулах журам"-ын 3.4-т 1-р курсээс бусад ангийн хичээл үйлдвэрлэлээс зарцуулж буй материалын зардлын 30-50 хувийг буцааж төвлөрүүлэхээр заасан ч тайлант хугацаанд төвлөрүүлсэн орлого байхгүй, албажуулсан тооцоолол анхан шатны баримт байхгүй, холбогдох албан хаагчдаас авлага үүсгээгүй,
8. Нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 691.0 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ хийгдсэн ч тайлан бүртгэлд тусгаагүй,
9. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй,
10. Нягтлан бодогч аудитын тогтоосон хугацаанд ирээгүй зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2, 72 дугаар зүйлийн 72.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.6, УСНББОУС-1, 12, 17, үнэлгээ ба хуваарилалт, толилуулга, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой байсан.

Гэвч, дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн улмаас санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөд үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой нотолгоо олж авах боломжгүй байна.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

БОЛОВСРУУЛСАН:

М. дор А. Гүлден

ХЯНАСАН

ҮҮВЬ

ОГНОО